

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Сангийн яамнаас боловсруулсан “Даатгалын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д² заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих боломж
3. Ойлгомжтой байдал
4. Харилцан уялдаа зэрэг болно.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

➤ Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан бэрхшээлийг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох билээ. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал буюу хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх, мөн

¹ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, <https://legalinfo.mn/mn/detail/11119>

² Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “Шалгуур үзүүлэлтийг тогтоохдоо тухайн боловсруулж байгаа хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно.”

түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Практикт хэрэгжих боломж**

Хуулийн төслийн үзэл баримтлалд хэд хэдэн шинэлэг зохицуулалтуудыг тусгасан бөгөөд тэдгээр зохицуулалтууд нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон. Тухайлбал, хуулийн төсөлд эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах, давхар даатгалын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох, дотоодын даатгагч нарын чадавхыг нэмэгдүүлэх, гадагш урсах валютын урсгалыг бууруулах зорилгоор давхар даатгалын тодорхой хувийг дотоодын давхар даатгагчид даатгуулах зохицуулалтыг тусгасан.

Мөн даатгагч нар даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга хэрэгслийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгаснаас гадна даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, заавал даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор өнөөгийн практик хэрэгцээ, шаардлага, олон улсын сайн туршлагад үндэслэн заавал даатгалын баталгаат сангийн зохицуулалтыг бий болгосон болно.

➤ **Ойлгомжтой байдал**

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд³ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ **Харилцан уялдаа**

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилдөөнгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонголоо.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

Монгол Улсын Их Хурлаас Даатгалын тухай хуулийг анх 1997 онд баталж, 2004 онд шинэчлэн найруулсан бөгөөд энэхүү хуулиар даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн.

³ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

Гэвч олон улсын болон хөгжлийн чиг хандлага, даатгалын салбарын цар хүрээ, нийгэм эдийн засагт үзүүлэх үүрэг оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотойгоор даатгалын салбарын эрх зүйн орчныг шинэчлэх зайлшгүй шаардлага бий болсон.

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, зорилт, зохицуулалтаас үзэхэд уг хуулийн төслөөр даатгалын үйл ажиллагааг зохицуулах, даатгуулагч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах зарчим хэвээр хадгалагдахаар байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий **“хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийх тул цаг хугацаа, нөөцийн хэмнэлт хийх үүднээс **“зардал тооцох”** шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Бусад орны эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах, мөн холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх
3	Ойлгомжтой байдал	Хуулийн зохицуулалтыг төслийг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн зохицуулалтыг төслийг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Үүний дагуу хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Давхар даатгалын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох, дотоодын даатгагч нарын чадавхыг нэмэгдүүлэх, гадагш урсах валютын урсгалыг бууруулах зорилгоор давхар даатгалын тодорхой хувийг дотоодын давхар даатгагчид даатгуулах зохицуулалтыг хуулийн төслийн 44 дүгээр зүйлд тусгасан байна. Мөн хуулийн төслийн 45, 46, 47 дугаар зүйлд даатгагч нар хамтран даатгал хийх болон даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга хэрэгслийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгаснаас гадна даатгагчийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, төслийн 58, 59, 60 дугаар зүйлд даатгалын хувьцаат компани, компанийн засаглалд тавигдах шаардлага, түүний хяналт, зохицуулалтын талаар тусгасан байгаа нь төслийн үзэл баримтлалд тусгасан “эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах” зорилгыг хангаж байна.

- Даатгалын зах зээл өндөр хөгжсөн орнуудын хувьд даатгалын зах зээлийн бүтэц буюу амьдралын болон амьдралын бус даатгал /ердийн даатгал/-ын харьцаа 55/45 байдаг бол манай улсын хувьд уг харьцаа нь 1/99 байна. Иймд даатгалын ангиллыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, амьдралын даатгалын тодорхойлолтыг илүү нарийвчилж, тогтолцоог нь боловсронгуй болгох, урт хугацааны хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх зэргээр амьдралын даатгал, тэтгэвэр, хуримтлалыг хөгжүүлэх, түүнийг бодлогоор дэмжих суурь зохицуулалтуудыг бий болгосон байгаа нь төслийн үзэл баримтлалд дурдсан “амьдралын даатгалын тогтолцоог боловсронгуй болгож, сайжруулах” зорилгыг хангаж байна.

- Хуулийн төслийн 55 дугаар зүйлд цахим даатгалын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байх бөгөөд бусад шаардлагатай зүйл заалтуудад даатгалын үйл ажиллагаанд цахим болон дэвшилтэт техник технологийг ашиглах, тухайлбал, даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөрийн хүсэлт гаргах, нөхөн төлбөр олгох, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргах, даатгагчийн санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх болон хяналт, шалгалт хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлбарыг ирүүлэх зэрэг аливаа үйл ажиллагаанд даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид цахим хэлбэрийг ашиглах боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг тусгасан байгаа нь төслийн үзэл баримтлалд дурдсан “даатгалын үйл ажиллагааг цахимжуулах” зорилгыг хангаж байна.

○ Хуулийн төслийн 7 дугаар зүйлд Монгол Улсын хуулиудад заавал даатгуулахаар тусгагдсан даатгалын үйл ажиллагааг заавал даатгал гэж тодорхойлон, тусгайлсан харилцааг тухайн хуулиар зохицуулахаар тусгасан байгаа нь төслийн үзэл баримтлалд тусгасан “заавал даатгалын тогтолцоог бий болгох” зорилгыг хангаж байна.

○ Мөн төслийн үзэл баримтлалд дурдсан “салбарын бусад зохицуулалтыг сайжруулах” зорилгын хүрээнд даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, заавал даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор өнөөгийн практик хэрэгцээ, шаардлага, олон улсын сайн туршлагад үндэслэн заавал даатгалын баталгаат сангийн зохицуулалтыг /66 дугаар зүйл/ бий болгосон байна. Заавал даатгалын баталгаат сан нь даатгагч дампуурах, түүний улмаас заавал даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна.

○ Түүнчлэн, Салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, бусад зохицуулалтыг сайжруулах зорилгын хүрээнд хуулийн төслийн 67 дугаар зүйлд салбарын мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлэх, 68 дугаар зүйлд даатгалын мэргэжлийн байгууллагыг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, 61 дүгээр зүйлд даатгалын хохирол үнэлэгч, 63-р зүйлд даатгалын орлогын шимтгэлтэй холбоотой зохицуулалтыг сайжруулах, 65-р зүйлд Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтыг шинэчлэх, сайжруулах зэргээр холбогдох өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгасан байна.

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх

Хуулийн төсөлд шинээр тусгасан зохицуулалтууд нь “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган олон улсын туршлагыг судлах, бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэхийг тодруулахыг зорилоо.

Хүснэгт-2

д/д	Хуулийн төслийн заалт	Практикт хэрэгжих боломж
1	7.1.Монгол Улсын хуульд заавал даатгуулахаар тусгасан даатгалын үйл ажиллагааг заавал даатгалын хэлбэрт хамруулах бөгөөд заавал даатгалтай холбогдох харилцааг тухайн хуульд тусгана. 7.2.Даатгагч нь заавал даатгалын хураамжийн 1 хүртэл хувийг байгаль орчин, нийгэмд ээлтэй ногоон бизнес, үйл ажиллагааг дэмжихэд зориулан зарцуулна.	Монгол Улсад мөрдөгдөж байгаа бусад салбарын 20 гаруй хууль, тогтоомжид мэргэжлийн үйл ажиллагаа явуулж байгаа этгээдийн хэрэглэгч, ажилтны эрх ашгийг хамгаалах зорилго бүхий албан журмын даатгалын 28 хэлбэр тусгагдсан байдаг. Гэтэл тэдгээрийн хэрэгжилтийг хангах механизм тодорхойгүй, хуулиар “заавал даатгал” гэх ойлголтыг тодорхойлоогүй, заавал даатгалын нэгдсэн бодлого зохицуулалтгүйн улмаас тус хуулиудын хэрэгжилтийн үр дүн, хяналт орхигдсон хэвээр байна. Иймд заавал даатгалын зохицуулалтыг хуулийн төсөлд тусгаснаар заавал даатгалын тогтолцоо боловсронгуй болох, хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлэх, хуулиудын хэрэгжилтийг хангуулахад чухал нөлөө үзүүлэхээр байна.
2	44 дүгээр зүйл. Давхар даатгал	2019-2023 онд буюу сүүлийн 5 жилийн хугацаанд даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 29.8 хувь буюу нийт 403.1 тэрбум төгрөгийг олон улсын

	44.1.Даатгагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ дараах даатгагчид давхар даатгуулж болно: 44.1.1.энэ хуулийн дагуу давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагчид; 44.1.2.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын давхар даатгагчид. 44.2.Даатгагч нь даатгалын гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгуулах тохиолдолд давхар даатгалд шилжүүлэх даатгалын үнэлгээний 5-аас доошгүй хувийг энэ хуулийн 44.1.1-д заасан даатгагчид даатгуулна. 44.3.Хороо давхар даатгалд даатгуулах нөхцөл, шаардлагаас хамааран энэ хуулийн 44.2-т заасан давхар даатгалд шилжүүлэх хувийг даатгалын төрөл тус бүрд ялгаатай тогтоож болно.	давхар даатгалын хураамжид зарцуулан эргүүлэн нөхөн төлбөрт 47.6 тэрбум төгрөгийг авсан байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд нийт 392.0 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласнаас 141.6 тэрбум /36.1%/ төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсан байна. Олон улсын туршлага: ОХУ-ын хуулинд заасны дагуу даатгалын компаниуд эрсдэлийн 10%-ийг заавал даатгуулдаг байна. Беларусь улс: Belarus Re төрийн өмчид давхар даатгалын компанийг 2006 онд үүсгэн байгуулсан. 2006 онд 10 хувь, 2007 онд 20 хувийг шилжүүлдэг болж, хуулинд нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөн ажиллаж байгаа. Дотоодын давхар даатгагчид даатгуулах хувийг хуульд зааж өгсний үр дүнд бүх давхар даатгалын гэрээ тус байгууллагаар дамждаг болж хяналт хийгдсэний дагуу Үндэсний давхар даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгож чадсан байна. Монгол улсын даатгалын зах зээлд давхар даатгалын 1 компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэхүү зохицуулалтыг тусгаснаар дотоодын даатгагч, давхар даатгагч нарын чадавх сайжрах, гадагш гарч байгаа давхар даатгалын хураамжийг тодорхой хувийг дотоодын зах зээлд үлдээх зэрэг ач холбогдолтой байна.
3	46 дугаар зүйл. Хамтын даатгал 46.1.Тэргүүлэх даатгагч эсхүл даатгалын брокер нь хамтын даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах ба энэхүү үүрэг нь хамтын даатгалын гэрээ дуусгавар болсноор мөн адил дуусгавар болно. 46.2.Даатгагч бүр хүлээн авсан эрсдэлийн хэмжээгээр энэ хууль болон Даатгалын журамд заасан даатгалын нөөцийг байгуулна. 46.3.Даатгалын тохиолдлын үед даатгагч бүр хүлээн авсан эрсдэлийн хувь хэмжээгээр хариуцлага хүлээнэ.	Өнөөгийн нөхцөлд даатгалын үнэлгээ өндөртэй даатгалын гэрээний хувьд дотоодын даатгагч компаниуд өөрийн хөрөнгө, эрсдэл даах чадвараасаа хамаарч даатгалын эрсдэлийн багахан хувийг даатгаад, дийлэнх хувийг гадаадын давхар даатгалд эрсдэлийг шилжүүлж байна. Иймд даатгагчдыг хамтран ажиллах таатай эрх зүйн орчныг бий болгох, хамтын ажиллагааг дэмжихэд чиглэсэн “хамтын даатгал”-ын зохицуулалтыг хуульд тусгаж өгснөөр үнэлгээ өндөр даатгалын гэрээ, тэдгээрийн хураамжийг дотооддоо авч үлдэх, гадагш гарч буй давхар даатгалын хураамжийг бууруулах, дотоодын даатгагч нарыг чадавхжуулах нөхцөл боломж бүрдэнэ.

4	47 дугаар зүйл. Даатгалын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл 47.1.Даатгагч нь даатгалын эрсдэлийг шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг ашиглан даатгалын эрсдэлийг шилжүүлж болно. 47.2.Энэ хуулийн 47.1-д заасан эрсдэл шилжүүлэх уламжлалт бус санхүүгийн хэрэгслийг ашиглах үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг Хороо батална.	Хөрөнгийн зах зээлийн тусламжтайгаар дотоодын давхар даатгалын зах зээлийг хөгжүүлэх, түүнчлэн гаднын хөрөнгө оруулагчдыг татах нэг арга зам нь эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга механизм юм. Тухайлбал олон улсад газар хөдлөлт, хар салхи гэх мэт байгалийн гамшгийн эрсдэлийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр даатгалын салбарт дутагдалтай байдаг тул 1990-д оноос Уламжлалт бус эрсдэлийг шилжүүлэх арга механизм - Alternative Risk Transfer-г ашиглан, даатгалын эрсдэлийг шилжүүлэх давхар даатгагчаас өөр субъект, эрсдэлийг үүрч, санхүүжүүлэх шинэ хөрөнгийн эх үүсвэрийг бий болгож эхэлсэн байдаг. Энэхүү жишгийн дагуу даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас (Insurance linked securities) буюу бонд, үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргах замаар хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгон, даатгалын эрсдэлийг тархаан байршуулж, даатгалын компаниудын эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэх боломжтой байна. Өөрөөр хэлбэл ART нь даатгагч болон давхар даатгагчдад илүү өргөн эх үүсвэрээс хөрөнгийн дутагдлыг арилгах нөхцөл боломжийг бүрдүүлэхийн сацуу хөрөнгө оруулагчдад өөрийн багцыг сайжруулан эрсдэлийг тараан байршуулахад чухал ач холбогдолтой байна.
5	66 дугаар зүйл. Заавал даатгалын баталгаат сан 66.1.Даатгагч дампуурсан, түүний улмаас заавал даатгалын даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах зорилгоор заавал даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий даатгагч нар хамтран заавал даатгалын баталгаат санг байгуулна. 66.2.Энэ хуулийн 66.1-д заасан сан нь мөнгөн хөрөнгийн сан байна. 66.3.Энэ хуулийн 66.1-д заасан заавал даатгалын баталгаат сангийн удирдлагыг Заавал даатгалын холбоо хэрэгжүүлнэ. 66.4.Заавал даатгалын баталгаат сангийн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах, түүнийг захиран зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулах журмыг Заавал	Хуулийн төсөлд даатгагч дампуурсны улмаас заавал даатгалд хамрагдсан даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор заавал даатгалын баталгаат сангийн талаарх зохицуулалтыг тусгасан байна. Заавал даатгалын баталгаат сангийн удирдлагыг ашгийн төлөө бус хуулийн этгээд буюу Заавал даатгалын холбоо хэрэгжүүлэх бөгөөд уг хуулийн этгээдийн удирдлага, зохион байгуулалт, эрх үүрэг, баталгаат сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх асуудлуудыг холбогдох хууль, тогтоомжоор зохицуулахаар байна. Заавал даатгалын баталгаат санг байгуулах практик хэрэгцээ, шаардлага, олон улсын сайн туршлагыг дурдвал: <u>Олон улсын туршлага:</u> Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын гишүүн 26 оронд (2013 оны байдлаар) даатгагч төлбөрийн чадваргүй болох, дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах зорилго бүхий даатгалын салбарын эрсдэлийг бүхэлд нь (нэгдсэн схем - Солонгос, Испани, Их Британи, хэд хэдэн схемийн хүрээнд Канад, Франц, Япон, АНУ), хэсэгчлэн (зөвхөн амьдралын бус даатгал – Австрали, Дани, Норвег,

	даатгалын холбооны саналыг харгалзан Хороо батална. 66.5.Даатгагч дампуурах, түүний улмаас даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах зорилгоор хэд хэдэн даатгагч нар хамтран сайн дурын даатгалын баталгаат санг байгуулж болно. 66.6.Энэ хуулийн 66.1-д заасан Заавал даатгалын баталгаат сан нь даатгагчийн дампуурсантай холбогдуулан түүний хохирогчдод олгосон нөхөн төлбөрийг дампуурсан даатгагчийн эрх залгамжлан авсан этгээдээс буцаан нэхэмжилнэ.	зөвхөн амьдралын даатгал – Австри, Герман, Грек,) эсхүл жолоочийн хариуцлагын даатгал, ажилчдын гэнэтийн осол, гуравдагч этгээдийн хариуцлага, хувийн эрүүл мэндийн даатгал зэрэг нэр бүхий даатгалын эрсдэлийг хамарсан Даатгуулагчийн хамгаалалтын схем (Policyholder Protection Scheme) байдаг байна. Даатгуулагчийн хамгаалалтын схемийг хэрэгжүүлдэг байгууллага нь олон улсад ашгийн бус төрийн өмчит, төрийн бус байгууллага, хувь нийлүүлсэн нийгэмлэг зэрэг харилцан адилгүй аж ахуйн үйл ажиллагааны хэлбэртэй байдаг бөгөөд жижиг, сул хөгжилтэй зах зээлийн хувьд тус схемийг төрийн байгууллага гүйцэтгэх нь тохиромжтой байдаг байна (Policyholder Protection Plan, Toronto centre, October 2015). Тухайлбал, Сингапур болон Их Британид төрийн хяналт, зохицуулалтын байгууллагаас удирдлагыг нь томилдог, түүнд ажлаа тайлагнадаг “Сингапурын хадгаламжийн даатгалын корпораци”, “Санхүүгийн үйлчилгээний нөхөн төлбөрийн схем” тус тус хязгаарлагдмал компани хэлбэрээр уг үйл ажиллагааг эрхэлдэг, харин Казахстан улсад 2003 онд хуулийн дагуу тус улсын Төв банкны харьяа “Даатгалын нөхөн төлбөрийн баталгаат сан” байгуулагдаж, 2008 онд сангийн хувьцааг бүхэлд нь түүний гишүүд-салбарын оролцогчдод худалдсан бөгөөд хувь нийлүүлсэн нийгэмлэг хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлдэг байна. Иймд даатгагч дампуурсны улмаас заавал даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор дотоодын практик хэрэгцээ, шаардлага, олон улсын сайн туршлагад үндэслэн заавал даатгалын баталгаат сангийн талаарх зохицуулалтыг бий болгосноор олон нийтийн даатгалд итгэх итгэл нэмэгдэх, салбарын нэр хүнд өсөх зэрэг эерэг нөлөөллийг бий болгохоор байна.
6	68 дугаар зүйл. Даатгалын мэргэжлийн байгууллага 68.1.Даатгалын мэргэжлийн байгууллага нь даатгалын мэргэжлийн оролцогчдоос бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох,	Даатгалын зах зээлд оролцогчдын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг тогтоох, түүнийг хэвшүүлэх, зарим хяналтыг хэрэгжүүлэх, салбарын суурь мэдээллүүдийг нэгтгэх, мэргэшлийн сургалт зохион байгуулах, мэдээлэл хүргэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх өөрийгөө зохицуулах байгууллагыг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлсэн зохицуулалтыг тусгасан байна. Ингэснээр салбарын хөгжилд мэргэжлийн холбоодын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх, салбарын хүний нөөцийг чадавхжуулах зэрэг ач холбогдолтой байна.

гишүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх, даатгалын зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий Хороонд бүртгүүлсэн хуулийн этгээд байна.	
---	--

Үнэлгээ:

Хуулийн төсөлд тусгасан дээрх шинэ зохицуулалтууд нь олон улсын туршлагад үндэслэсэн, бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах этгээд байгаа тул хуулийн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх боломжтой байна.

3. Ойлгомжтой эсэх

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Хүснэгт-3

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Хуулийн төсөл нь бүхэлдээ уг шаардлагыг хангасан.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Хуулийн төсөл нь бүхэлдээ уг шаардлагыг хангасан.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Тийм асуудал тусгаагүй байна.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан бөгөөд нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгаагүй.

29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Уг шаардлагыг хангасан.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Дагах хуулийн төслийг боловсруулсан.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан.

4. Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийн бүх заалтын хүрээнд үзэхээр тооцлоо. Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэлснийг хүснэгт 4-с үзнэ үү.

Хүснэгт-4

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
-----	--------	---------	---------------

1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Бүрэн нийцэж байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй бөгөөд бусад хуулийн заалттай нийцэж байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Бусад хуулийн заалттай давхардаагүй байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Хуулийн төслийн хүрээнд орхигдуулсан зохицуулалт илрээгүй.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Давхардал илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	Тийм	Хуулийн төсөлд даатгалын мэргэжлийн байгууллагын зохицуулалтыг тусгасан бөгөөд холбогдох шаардлагыг хангасан тохиолдолд тодорхой чиг үүргийг шилжүүлэх боломжтой байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоогоогүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх	Тийм	Тусгай зөвшөөрлийн зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан.

12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хязгаарласан зохицуулалт илрээгүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөл жендерийн тэгш байдлыг хөндөөгүй байна
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Өрсөлдөөнийг хязгаарласан зохицуулалт илрээгүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусаагүй байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Даатгалын тухай хууль болон Зөрчлийн тухай хуулиар зохицуулахаар тус тус тусгасан байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах Дүгнэлтийг хийж, Зөвлөмж боловсрууллаа.

4.1.ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал болон хуулийн төсөлтэй танилцаж, үр дагавар үүсгэж байгаа гол ач холбогдолтой гэсэн заалтуудыг сонгох болон бүхэлд нь авч үзэж, аргачлалд заасан үе шат бүрийн дагуу хийгдсэн ажиллагааны хүрээнд энэхүү дүгнэлтийг гаргаж байна:

1.Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа эсэх болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалт хангаж, илэрхийлж чадахаар бүрэн, гүйцэт томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

2.Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төсөлд тусгагдсан шинэлэг зохицуулалтуудыг онцгойлон авч үзэхэд тухайн зохицуулалттай холбоотой хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд түүнийг хэрэгжүүлэх этгээд тодорхой, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж байгаа тул практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

3.Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр: Хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхэд Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан гэж үзэж байна.

4.Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр: Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгасан. Харилцан уялдаатай байдлыг хангасан байна.

4.2.ЗӨВЛӨМЖ

Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд үндэслэн энэхүү хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан, хуулийн төслийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга, төслийн үр нөлөөг тооцсон үнэлгээний тайлан, зардлын тооцоо зэрэг холбогдох бүрдлийн хамт уг хуулийн төслийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх боломжтой байна.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Хууль тогтоомжийн тухай хууль;
2. Иргэний хууль;
3. Зөрчлийн тухай хууль;
4. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол;
5. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2024 он. Сангийн яам;
6. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2024 он. Сангийн яам;
7. Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд. 2024 он. Сангийн яам.